

## БОЛОВСРОЛЫН ГАЗРЫН 2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН АЖЛЫН МЭДЭЭЛЭЛ

2026.05.01.

Сургалт арга зүйн хэлтэс нь 2026 оны 04 дүгээр сард 4 зорилтын хүрээнд 32 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэн ажилласан ба томоохон ажлын үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнг тайлагнаж байна.

### 1. ХӨГЖИЛ ОРОЛЦОО, ХАМТЫН АЖИЛЛАГААГ ХАНГАХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

Салбарын цахим хуудас болон удирдах ажилтнуудын уулзалтаар мэдээлэл солилцоог зохион байгуулж, 59 байгууллагад мэдээлэл, зөвлөмж, чиглэлийг хүргэн удирдлагаар ханган ажиллав.

### 2. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

#### УЛСЫН ФИЗИКИЙН XXXVII ОЛИМПИАД:

Дорнод аймгийн Баяндун сумын харьяат, Монгол Улсын анхны онолын физикч, нэрт эрдэмтэн Дугаржавын Цэрэнгийн нэрэмжит Улсын физикийн XXXVII олимпиад 2026 оны 04 дүгээр сарын 04-07-ны өдрүүдэд Дорнод аймгийн Чойбалсан хотноо зохион байгуулагдлаа.

Тус олимпиадад 21 аймаг, 9 дүүргээс шалгарсан 13-74 насны нийт 152 багш, сурагч оролцон, мэдлэг, ур чадвараа сорин өрсөлдөж, шилдгүүдээ тодрууллаа.

Олимпиадыг Боловсролын яам, Монгол Улсын их сургууль, Шинжлэх ухаан, технологийн их сургууль, Монгол Улсын Боловсролын их сургууль, Монголын физикийн олимпиадын хороо хамтран зохион байгууллаа.

Тус олимпиадыг зохион байгуулахад жил ирэх бүр олон улсын жишигт нийцсэн байхаар их, дээд сургуулийн багш нарын бүтээсэн туршилтын багажийг ашиглах, үр дүнг тооцоход ухаалаг технологийг нэвтрүүлэх зэрэг шинэчлэлийг нэвтрүүллээ.

Онцлох шинэчлэлүүдээс дурдвал:Шагналын системийг олон улсын жишигт нийцүүлэн оролцогчдын 30 хувийг шагналт байрт шалгаруулсан нь өрсөлдөөнийг нэмэгдүүлж, физикийн шинжлэх ухаанд сонирхолтой сурагчдын оролцоог дэмжих ач холбогдолтой.

Байгалийн шинжлэх ухааны хичээлийн сурагчдын бүтээлийн үзэсгэлэн гаргаж, физикийн лабораторийн багаж ашигласан туршилтын уралдааныг зохион байгуулсан;

Цахим технологийн шийдлийг “Mexim Consulting” ХХК болон “Medle” цахим сургууль хамтран боловсруулж, олимпиадын зохион байгуулалтыг дэмжин ажиллав.



Шагнал гардуулах явцаас



УФО-ын тугийг Баян-Өлгий аймагт шилжүүлэв.

**Эх сурвалж:** Дорнод аймгийн Боловсролын газар Сургалт арга зүйн хэлтэс, 201 тоот Хэлтсийн дарга Ж.БУМТУЯА Емэйл: [bumtuyaa5fvk@moes.edu.mn](mailto:bumtuyaa5fvk@moes.edu.mn) Утас: 99588832

### **ЗҮҮН БҮСИЙН АНГЛИ ХЭЛНИЙ БАГШ НАРЫН ЧУУЛГАН**

Монгол Улс дахь АНУ-ын элчин сайдын яам, Монголын англи хэлний багш нарын холбоо, аймгийн Боловсролын газрын дэмжлэгтэйгээр Дорнод аймгийн Хэрлэн сумын 1 дүгээр сургуулийн санаачлагаар англи хэлний багш нарын “Зүүн бүсийн англи хэлний багш нарын чуулга уулзалт” зохион байгуулж, зүүн бүсийн 5 аймгийн 120 англи хэлний багш нар оролцов.

Чуулганы нээлтэд аймгийн Засаг даргын орлогч оролцож аймгаас боловсролын салбарт хэрэгжүүлж байгаа мэдээллийг танилцууллаа.

Монгол Улсын Засгийн газраас 2026 оныг “Боловсролыг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан боловсролын салбарт олон ажлыг үе шаттай зохион байгуулж байна.



Чуулга уулзалтын хэсгээс

### **ДОТУУР БАЙРНЫ БАГШ НАРЫГ ЧАДАВХЖУУЛАХ СУРГАЛТ**

Дотуур байрны багш нарыг чадавхжуулах зорилгоор "Хүмүүжлийн эерэг арга" сургалтыг зохион байгууллаа.

Сургалтаар:

- Хүүхдийн нас ба хөгжлийн онцлог, түүнийг таньж ойлгох нь
- Хүүхдийн өсөлт хөгжил, нийгэм болон сэтгэл зүйн үндсэн хэрэгцээ
- Хүүхэдтэй зүй бус харилцах харилцааны хэлбэрүүд
- Сахилга баттай болгох ба шийтгэлийн ялгаа, эцэг эхчүүдийн гаргадаг нийтлэг алдаа
- Хүүхдийг хүмүүжүүлэх эерэг аргууд, түүнд суралцах нь
- Сонсох арга, урамшуулах арга, гэр бүлийн хурал ба гэр бүлийн дүрэм тогтоох, хэрэгжүүлэх аргад суралцах нь сэдвээр сургалт зохион байгууллаа.



Сургалтын явцаас

### **ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН СУРГАЛТ**

"Боловсролыг дэмжих жил"-ийн хүрээнд Боловсролын газар санаачлан, Дорнод аймгийн ХАБЭА-н зөвлөлийн дэмжлэгтэйгээр ЕБС-ийн ХАБЭА-н асуудал хариуцсан

**Эх сурвалж:** Дорнод аймгийн Боловсролын газар Сургалт арга зүйн хэлтэс, 201 тоот Хэлтсийн дарга Ж.БУМТУЯА Емэйл: [bumtuyaa5fvk@moes.edu.mn](mailto:bumtuyaa5fvk@moes.edu.mn) Утас: 99588832



ажилтнуудыг мэргэшүүлэх сургалтыг Дорнод аймаг дахь Политехник коллежтой хамтран зохион байгуулж байна.

Тус сургалтаар Боловсролын ерөнхий хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль, тогтоомж, бусад дүрэм, журам, сургалтын байгууллагын орчин дахь стандартын шаардлага, аюул эрсдлийг илрүүлэх, түүнээс урьдчилан сэргийлэх, хэрэгжилтийг сайжруулах арга зүйг олгож байгаа юм.

Мөн Дорнод Политехник коллеж нь шинээр засварлан тохижуулсан 50 хүний багтаамжтай, ХАБЭА-ны сургалтын төвийн нээлтийн арга хэмжээг зохион байгууллаа.



*Сургалтын явцаас*

## **ХАМТЫН АЖИЛЛАГАА**

Дорнод аймаг дахь Политехник коллеж “Мэргэжилтэй цэрэг” хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болон “Батлан хамгаалахын сэргэлт” бодлогын хүрээнд хугацаат цэргийн алба хаагчдад цэргийн эрдмээс гадна эрэлттэй мэргэжил эзэмшүүлж, мэргэжлийн үнэмлэхтэй халах зорилт бүхий “Мэргэжилтэй цэрэг” хөтөлбөр улсын хэмжээнд хэрэгжиж байна.

Энэхүү бодлогын хэрэгжилтийг орон нутагтаа түүчээлэн, Дорнод аймаг дахь Политехник коллеж нь Зэвсэгт хүчний 0327 дугаар анги болон Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газартай хамтын ажиллагааны гэрээ байгуулан, сургалтын үйл ажиллагааг зохион байгууллаа.

Тус коллеж 2026 оны 04 дүгээр сарын 06-ны өдрөөс эхлэн нийт 92 хугацаат цэргийн алба хаагчид дараах гурван чиглэлээр мэргэжлийн ур чадвар олгох сургалтыг эхлүүлээ.

- Гагнуурчин
- Цахилгаан хангамж, тоног төхөөрөмжийн ашиглалт
- Механикжсан тээврийн хэрэгсэл, механизмын засвар үйлчилгээ

Сургалтыг Боловсролын ерөнхий хууль болон холбогдох салбарын сайд нарын хамтарсан тушаал, журмын дагуу мэргэжлийн өндөр түвшинд явуулж байгаа бөгөөд Политехник коллежийн чадварлаг багш нар онол, практик хосолсон хичээлийг зааж байгаагаараа онцлог юм.

Хугацаат цэргийн алба хаагчид албаа хаах зуураа Политехник коллежийн сургалтад хамрагдаж, нарийн мэргэжил эзэмшсэнээр халагдсанаа дараа орон нутагтаа шууд ажлын байртай болох, цаашлаад амьдралын баталгаагаа хангах бодит боломж бүрдэж байна.

**Эх сурвалж:** Дорнод аймгийн Боловсролын газар Сургалт арга зүйн хэлтэс, 201 тоот Хэлтсийн дарга Ж.БУМТУЯА Емэйл: [bumtuyaa5fvk@moes.edu.mn](mailto:bumtuyaa5fvk@moes.edu.mn) Утас: 99588832

## ХАМТЫН АЖИЛЛАГАА

“Гэр бүлийн бахархал” нийгэмд үйлчлэх төрийн бус байгууллагаас багш нарын хувь хүний хөгжил, мэргэжлийн ур чадварыг дэмжих зорилгоор **“Хөгжиж өөрчлөгдөх амжилтын нууц”** сэдэвт сургалтыг Хэрлэн сумын ерөнхий боловсролын 10 сургуулийн 199 багш нарыг хамруулан зохион байгууллаа.



## ХАМТЫН АЖИЛЛАГАА

Боловсролын ерөнхий газар, Хүүхэд, гэр бүл, хөгжил, хамгааллын газар болон - Дэлхийн зөн Монгол Олон улсын байгууллага Дорнод орон нутгийн хөтөлбөртэй хамтран Политехникийн коллеж болон ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны 17 багшийг хамруулсан мэргэжлийн бүлгийн сургалт, хэлэлцүүлгийг зохион байгууллаа.

Сургалт, үйл ажиллагааны хүрээнд: “Гэр бүлийн баяр хөөр”, “Хүмүүжлийн эерэг арга” сэдэвт чадваржуулах сургалт, дотуур байрны багшийн хөгжил, хууль эрх зүйн орчин болон анхаарах асуудлууд, багш нарын шилдэг туршлага солилцох үйл ажиллагаанууд тус тус явагдлаа.

Энэхүү ажлын үр дүнд оролцогч багш нар хүмүүжлийн эерэг арга зүйд суралцаж, хүүхэд хөгжил, хамгаалал, мэргэжлийн хөгжил, хууль эрх зүйн мэдээллээр хангагдлаа.



Сургалтын явцаас

## ХАМТЫН АЖИЛЛАГАА

Дэлхийн Зөн Монгол Олон Улсын Байгууллагын Дорнод орон нутгийн хөтөлбөрөөс аймгийн Боловсролын газартай хамтран “Тэгш хамруулан сургах боловсрол”-ын сургагч багш бэлтгэх модуль II сургалтыг танхимаар зохион байгууллаа. Тус сургалтад ерөнхий боловсролын сургуулийн 20, цэцэрлэгийн 6, нийт 26 багш хамрагдсан. Мөн арга хэмжээний хүрээнд 9 багш, 5 эцэг эх, асран хамгаалагчдад ганцаарчилсан зөвлөгөө, мэдээлэл өглөө.

## СУРГАЛТЫН МЕНЕЖЕРИЙН МЭРГЭЖЛИЙН БҮЛГИЙН АЖИЛ:

**Эх сурвалж:** Дорнод аймгийн Боловсролын газар Сургалт арга зүйн хэлтэс, 201 тоот Хэлтсийн дарга Ж.БУМТУЯА Емэйл: [bumtuyaa5fvk@moes.edu.mn](mailto:bumtuyaa5fvk@moes.edu.mn) Утас: 99588832



V бүсийн сургалтын менежерүүд мэргэжлийн бүлгийн ажлыг ерөнхий боловсролын Хан-Уул сургуульд зохион байгуулсан. Мэргэжлийн бүлгийн ажилд аймгийн төв болон Чойбалсан, Гурванзагал сумын ерөнхий боловсролын сургуулийн сургалтын менежер, нийт 22 хүн танхимаар оролцож, бусад менежерүүдэд “Дорнодын ЕБС-ийн захирал, менежерүүд” пэйж хуудсаар шууд лайв хийн түгээсэн. “Pearson” хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Хан-Уул сургуулийн англи хэлний багш О.Баасанжаргал “Sport day” сэдвээр 5в ангид англи хэлний үзүүлэх хичээл зааж, БГ-ын ахлах арга зүйч Ө.Болорчимэг чиглүүлэн хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Хичээлийн хэлэлцүүлэгт 22 сургалтын менежер, туршилтын 1 сургуулийн англи хэлний багш Г.Эрдэнэ, Хан-Уул сургуулийн англи хэлний 11 багш танхимаар оролцон Пийрсон хөтөлбөрийн хичээл төлөвлөлт, платформ ашиглалт, судалж буй байдал, хэрэглэгдэхүүн ашиглалт, суралцагчдын оролцоо, хэлний хэрэглээний чадварын зөрүү, хичээл ажиглах талаар санал дүгнэлтээ хэлэлцүүлээ.

Баян-Уул сумын багшийн хөгжил хариуцсан сургалтын менежер Б.Энхжаргал “Төлөвлө, тайлагна” арга зүй, 2 дугаар сургуулийн багшийн хөгжил хариуцсан сургалтын менежер Б.Цэрмаа “60 хором” арга зүй, Хан-Уул сургуулийн хөтөлбөр хариуцсан сургалтын менежер “Илтгэлийн цаг” сурагчдын бие даах чадварыг нэмэгдүүлж байгаа туршлага арга зүйгээ түгээн дэлгэрүүлсэн. Сургалтын менежерүүдийн сайн төлөвлөлт үр дүнд хүргэдэг, хүүхэд бүрийн тоогоор брошур боловсруулан үйл ажиллагаагаа танилцуулдаг, багшийн хөгжлийг ханган зорилтот бүлгээр нь сонгон авч, идэвхтэй сургалтын аргыг эзэмшүүлэх, эргэцүүлэлд суурилсан ээлжит хичээл төлөвлөх чадварыг хөгжүүлсэн, хамтын суралцахуйг дэмжиж хөгжүүлсэн, багшийн хөгжлийн хяналтын хуудас ашигладаг, 3 минутын илтгэл үйл ажиллагаанаас эхлээд экстемт илтгэл болтол үйл ажиллагаагаа өргөжүүлсэн, илтгэлийг тулгамдсан асуудалд нь тулгуурлан бичих чадварт сургасан зэрэг олон сайн туршлага байсан.

### **ОЮУНЛАГ БАГШ, СУРАЛЦАГЧДАА ХҮЛЭЭН АВЧ, ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЛЭЭ.**

Боловсролын салбарт оюун ухаан, мэдлэг чадвараараа манлайлж, улсын хэмжээний олимпиад болон эрдэм шинжилгээний илтгэлийн уралдаанд амжилт гаргасан багш, суралцагчдыг Боловсролын газар хүлээн авч уулзлаа.

Улсын төрөлжсөн олимпиад 12 хичээлээр шилдгүүдээ шалгаруулахад Дорнод аймгийн 14 багш, суралцагчид 10 хичээлд аймгийнхаа нэрийг дуурсган алт, мөнгө, хүрэл медаль хүртсэн. Уулзалтын үеэр амжилт гаргасан багш, сурагчдад дурсгалын зүйлс, талархал гардуулан, цаашдын сурлага хөдөлмөрт нь өндөр амжилт хүсэн урамшууллаа.

Нутгийнхаа нэрийг улсын тавцанд гаргасан багш, суралцагчдын энэхүү бахархам амжилт нь бусад үе тэнгийнхэндээ үлгэр дуурайл болохын зэрэгцээ боловсролын чанар, чансааг илтгэсэн чухал үйл явдал боллоо.



**Эх сурвалж:** Дорнод аймгийн Боловсролын газар Сургалт арга зүйн хэлтэс, 201 тоот Хэлтсийн дарга Ж.БУМТУЯА Эмэйл: [bumtuyaa5fvk@moes.edu.mn](mailto:bumtuyaa5fvk@moes.edu.mn) Утас: 99588832

## **ХҮҮХДИЙН ХӨГЖИЛ ХАМГААЛАЛД ЭЦЭГ ЭХИЙН ОРОЛЦОО” СЭДЭВТ СУРГАЛТ ЗӨВЛӨГӨӨН**

Хүүхдийн хөгжил хамгаалал бол зөвхөн цэцэрлэг, сургууль, багшийн үүрэг бус эцэг эх асран хамгаалагчид бүгдийн хамтын үүрэг юм. Боловсролыг дэмжих жилийн хүрээнд Дорнод аймгийн СӨБ-ын 4-р бүсийн Хэрлэн сумын 4,9,17-р цэцэрлэг, Баяндун, Баянтүмэн Гурванзагал сумын хүүхдийн цэцэрлэгүүдийн эцэг эх асран хамгаалагч нарын оролцоог дэмжих “Хүүхдийн хөгжил хамгаалалд эцэг эхийн оролцоо” сэдэвт сургалт зөвлөгөөнийг 04 дүгээр сарын 11-ний өдөр нийт 200 эцэг эх асран хамгаалагчид 100 гаруй багш ажилчдын оролцуулан зохион байгууллаа.

Сургалт зөвлөгөөнөөр "Хүүхэд зорчиж байна" ТББ ын сургагч багш Сансархүү "10 хүртэлх насны хүүхдийг зам тээврийн осол зөрчлөөс сэргийлэх аргачлал" сэдвээр сургалтыг зохион байгуулж хүүхэд хамгаалалын мэдээлэлийг өгсөн ба аймгийн ГБХЗХГ, Боловсролын газар, Цагдаагийн газрын замын цагдаагийн тасаг, ОБГ-ын төлөөлөл зочид урилгаар оролцлоо.

Мөн бүсийн цэцэрлэгүүдээс сургуулийн өмнөх боловсролын шинэчилсэн хөтөлбөрийн хэрэгжилтийг танилцуулах сургалтын хэрэглэгдэхүүний үзэсгэлэн, хүүхдийн хоол хүнсний материал нийлүүлэлтийн болон технологийн мэдээлэлийг хүргэж ажиллалаа.



*Эцэг эхийн зөвлөгөөний явцаас*

### **ХӨНДЛӨНГИЙН ҮНЭЛГЭЭ:**

2 дугаар ангийн “Монгол хэл” хичээлийн хөндлөнгийн үнэлгээнд 56 бүлгийн 1955 суралцагчаас 1827 суралцагч оролцож, 128 суралцагч оролцоогүй ба 71.9 хувийн гүйцэтгэлтэй. 2 дугаар ангийн “Математик” хичээлийн хөндлөнгийн үнэлгээнд 56 бүлгийн 1955 суралцагчаас 1822 суралцагч оролцож, 133 суралцагч оролцоогүй ба 70,4 хувийн гүйцэтгэлтэй. 3 дугаар ангийн “Монгол хэл” хичээлийн хөндлөнгийн үнэлгээнд 62 бүлгийн 1957 суралцагчаас 1842 суралцагч оролцож, 112 суралцагч оролцоогүй ба 78.8 хувийн гүйцэтгэлтэй. 3 дугаар ангийн “Математик” хичээлийн хөндлөнгийн үнэлгээнд 62 бүлгийн 1957 суралцагчаас 1796 суралцагч оролцож, 118 суралцагч оролцоогүй ба 76.8 хувийн гүйцэтгэлтэй.

### **ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД ЗӨВЛӨН ТУСЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА:**

Хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах, зөвлөн туслах үйл ажиллагааны удирдамжийн дагуу 2026 оны 04 дүгээр сарын 22-23, 29-30-ны өдөр Халхгол, Чулуунхороот сумын ерөнхий боловсролын сургуульд зөвлөн тусалж, арга зүйн дэмжлэг үзүүллээ. Ажиллах хугацаандаа .... багшийн хичээлд сууж, давхардсан тоогоор ... багш, удирдах ажилтанд **Эх сурвалж:** Дорнод аймгийн Боловсролын газар Сургалт арга зүйн хэлтэс, 201 тоот

Хэлтсийн дарга Ж.БУМТУЯА Емэйл: [bumtuyaa5fvk@moes.edu.mn](mailto:bumtuyaa5fvk@moes.edu.mn) Утас: 99588832

ганцаарчилсан зөвлөгөөг өгч, ...багш, удирдлага, ажилтны бичиг баримт, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөтэй танилцав. Боловсролын ерөнхий хууль, сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийг байгууллага, олон нийтэд сурталчлан таниулах, боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, арга зүй, үнэлгээ, технологи хэрэгжилтэд хяналт тавин, багш, удирдах ажилтныг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийн хэрэгжилт, үр дүн, сургалтын байгууллагын менежментийг сайжруулах чиглэлээр зөвлөн тусаллаа.

Зөвлөн туслах багийн гишүүд сургуулийн захирал, сургалтын менежер, нийгмийн ажилтан, байгууллага дахь дотоод нэгж, ажлын хэсгүүд болон мэргэжлийн багш нарт зөвлөн тусалж, багш бүрд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлээ.

Сургуулийн удирдах ажилтны манлайлал, хамт олны хандлагыг тандах асуулгыг албан хаагчаас, боловсролын багц хуулийн талаарх тандалт судалгаанд багш, удирдах ажилтныг хамрууллаа.

## **БОЛОВСРОЛЫН ГАЗРЫН 2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН АЖЛЫН МЭДЭЭЛЭЛ**

2026.06.25.

Сургалт арга зүйн хэлтэс нь 2026 оны 06 дугаар сард 4 зорилтын хүрээнд 22 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэн ажилласан ба томоохон ажлын үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнг тайлагнаж байна.

### **2. ХӨГЖИЛ ОРОЛЦОО, ХАМТЫН АЖИЛЛАГААГ ХАНГАХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:**

Салбарын цахим хуудас болон удирдах ажилтнуудын уулзалтаар мэдээлэл солилцоог зохион байгуулж, 59 байгууллагад мэдээлэл, зөвлөмж, чиглэлийг хүргэн удирдлагаар ханган ажиллав. Анги дэвших шалгалтын 3-12 дугаар ангийн 16 судлагдахууны шалгалтад бага боловсролын 4166, суурь боловсролын 5873, бүрэн дунд боловсролын 2752 нийт 12553 суралцагч шалгагдаж, өвчтэй 69, чөлөөтэй 77, тасалсан 11 суралцагч байв. Улсын шалгалтын 5, 9, 12 дугаар ангийн 13 судлагдахууны 11 шалгалтад бага боловсролын 1887, суурь боловсролын 1774, бүрэн дунд боловсролын 1410 нийт 5071 суралцагч шалгагдаж, өвчтэй 17, чөлөөтэй 12, тасалсан 2 суралцагч байв.

### **2.БАГШИЙН ХӨГЖЛИЙН ДЭМЖСЭН АРГА ЗҮЙ, СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ ХИЙЖ, ҮР ДҮНГ ТООЦОХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД**

Цэцэрлэгийн багш, бага боловсролын багш нарын хөдөлмөрийн үнэлэмж, мэргэжлийн нэр хүндийг дээшлүүлэх, нийгмийн хамгааллыг дэмжих, боловсролын олон талт үйл ажиллагаанд багш нарыг хамруулах, багшлахуйн ур чадвар, санал, санаачилгыг дэмжин урамшуулах, хүүхэд бүрийн хөгжлийг дэмжих шилдэг арга зүй, тэргүүн туршлагыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор 2026 оны 2-5 дугаар сард явагдсан "Цэцэрлэгийн багш" болзолт уралдаан, "Бага ангийн багшийг дэмжих" төсөлд шалгарсан багш нарын батламж гардуулах үйл ажиллагааг зохион байгуулагдлаа.

**Эх сурвалж:** Дорнод аймгийн Боловсролын газар Сургалт арга зүйн хэлтэс, 201 тоот Хэлтсийн дарга Ж.БУМТУЯА Емэйл: [bumtuyaa5fvk@moes.edu.mn](mailto:bumtuyaa5fvk@moes.edu.mn) Утас: 99588832





### *Орон сууцны урьдчилгаа авсан багш нар*

-Аймгийн Засаг даргын 2026 оны 01дүгээр сарын 21-ний өдрийн А/47 тоот захирамжаар батлагдсан "Цэцэрлэгийн багш" болзолт уралдаан 2026 оны 02-05 дугаар сард 2 үе шат 6 даалгавартай явагдав. Тус уралдааны "Багш" төрөлд 34 бүлгийн багш, "Багшийн туслах" төрөлд 19 нийт 53 багш оролцож, сүүлийн даваанд 4 хүн шалгарсан.

-Аймгийн Засаг даргын 2026 оны 01 сарын 21-ний өдрийн А/44 тоот захирамжаар батлагдсан "Бага ангийн багшийг дэмжих" төсөлд 20 сургуулийн 42 багш 1, 2 дугаар шатны шалгаруулалтад оролцож, 3 дугаар шатанд 32 багш өрсөлдөж, 20 багш шалгарсан.

"Бага ангийн багшийг дэмжих" төслийн 3 дугаар шатны шалгаруулалт үндсэн 2 чиглэлээр зохион байгуулагдсан. Үүнд:

1. Хүн ба байгаль хичээлийн туршилт, суралцагчдад зориулсан танин мэдэхүйн олон талт үйл ажиллагаа чиглэлээр сургуулийн орчинд 33.0039.89 төгрөгийн бүтээлч ажил буюу хөрөнгө оруулалт хийсэн байна.
2. Mozaik education хэрэгжилт, үр дүн, хүн ба байгаль хичээлийн хүндэвтэр агуулгын хүрээнд орчин, хэрэглэгдэхүүн чиглэлээр 36.930.589 төгрөг нийт 69.934.578 төгрөгийн бүтээлч ажлыг хийсэн байна.



### *Батламж гардуулах үйл ажиллагаа*

**Эх сурвалж:** Дорнод аймгийн Боловсролын газар Сургалт арга зүйн хэлтэс, 201 тоот Хэлтсийн дарга Ж.БУМТУЯА Емэйл: [bumtuyaa5fvk@moes.edu.mn](mailto:bumtuyaa5fvk@moes.edu.mn) Утас: 99588832



## AI ҮНДЭСНИЙ СУРГАГЧ БАГШ НАР БЭЛТГЭГДЛЭЭ.

“AI Academy Asia”-гийн санаачилга, Голомт банкны дэмжлэгтэйгээр хэрэгжсэн “National AI Campaign” хөтөлбөрт Дорнод аймгийн 10 сургуулийн 31 багш, Боловсролын газрын 1 ахлах арга зүйч нийт 32 багш, ажилтан амжилттай хамрагдлаа.

3 сарын хугацаанд үргэлжилсэн сургалтаар багш нар хиймэл оюуны суурь мэдлэг, AI хэрэгслийг сургалтад үр дүнтэй ашиглах арга зүйд суралцаж, цаашид сургуулиуддаа AI боловсролыг түгээн дэлгэрүүлэх үндэсний сургагч багшаар бэлтгэгдсэн.

Мөн Дорнод, Сүхбаатар аймгийн 45 багш хамтран “Бүтээлч уншлага” төслийг хөгжүүлж, 1–9 дүгээр ангийн сурагчдын уншаад ойлгох чадварыг дэмжих эх, үлгэр, зохиол, интерактив дасгал, хиймэл оюунд суурилсан тоглоом бүхий нээлттэй цахим платформыг танилцууллаа. Багш нарын хамтын ажиллагаа, инновац, хиймэл оюуны хэрэглээг боловсролд нэвтрүүлэх энэхүү санаачилга нь сургалтын чанарыг дээшлүүлэхэд бодит хувь нэмэр оруулах чухал алхам боллоо.



*Хиймэл оюунд суурилсан тоглоом бүхий нээлттэй цахим платформыг танилцуулж буй хэсгээс*

## “БҮТЭЭЛЧ САМБАР, СУРАГЧИЙН ИРЭЭДҮЙ” АЯН

Бага боловсролын багш нарын самбар төлөвлөлтийн шилдэг арга зүй, ур чадварыг хуваалцах, харилцан суралцах зорилготой “Бүтээлч самбар – Сурагчийн ирээдүй” аян амжилттай өрнөж, дүнгээ гаргалаа.

Энэхүү аяныг суралцагчдын идэвх оролцоо, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, самбарыг оновчтой төлөвлөх замаар ээлжит хичээлийн чанарыг сайжруулахад чиглүүлэн, ЕБС-д 8-20 дахь жилдээ ажиллаж буй бага ангийн багш нарын дунд зохион байгуулсан юм. Багш нар 2026 оны 4-6 дугаар сард өөрсдийн бүтээлч самбар төлөвлөлтийн зургуудыг “Дорнод бага боловсрол” бүлгэмд байршуулн оролцлоо.





*Бүтээлч самбар төлөвлөлтийн хэсгээс*

Нийт 15 сургуулийн 51 багш хамрагдан, 4 судлагдахуунаар, нийт 182 цагийн самбар төлөвлөлтийн шинэлэг арга зүйг түгээн дэлгэрүүллээ. Нэг багш хамгийн олондоо 14 ээлжит хичээлийн самбар төлөвлөлтийг байршуулж идэвхтэй оролцсон байна.

Уралдааныг 5 хүний бүрэлдэхүүнтэй шүүгчдийн баг дараах 10 үндсэн шалгуураар үнэлж дүгнэж, оролцогч багш нарын 25 хувь буюу өндөр үнэлгээ авсан эхний 13 багшийг шалгаруулан урамшууллаа.

### **СУРАЛЦАГЧИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД**

2026 оны 6 дугаар сарын 05–06-ны өдрүүдэд Дорнод аймагт физикийн хичээлээр Элсэлтийн шалгалт өгөх суралцагчдын амжилтыг ахиулах, бодлого бодох оновчтой арга барил эзэмшүүлэх, онолын мэдлэгийг системчлэн бататгах зорилготой эрчимжүүлсэн сургалт зохион байгуулагдав. Тус сургалтыг Монгол Улсын Их Сургуулийн багш нар удирдан явуулж, элсэлтийн шалгалтад бэлтгэх үр дүнтэй арга зүй, бодлого бодох техник, шалгалтын стратегийн талаар мэдлэг олгон, суралцагчдын мэдлэг чадварыг бататгахад үнэтэй хувь нэмэр орууллаа. Сургалтад ерөнхий боловсролын 18 сургуулийн 165 суралцагч хамрагдсан бөгөөд суралцагчид онолын мэдлэгээ бататгахын зэрэгцээ шалгалтын бодлого бодох ур чадвараа хөгжүүлсэн үр дүнтэй арга хэмжээнд оролцлоо. Мөн физикийн багш нарт зориулсан туршилт, дадлага ажлын сургалт зохион байгуулж, сургалтын чанарыг сайжруулах, лабораторийн ажлыг үр дүнтэй хэрэгжүүлэх арга зүй, сайн туршлагыг харилцан солилцов. Улсын физикийн олимпиадын хүрээнд ерөнхий боловсролын 23 сургуульд нийт 48 сая төгрөгийн өртөг бүхий физикийн 6 багц, 140 ширхэг багаж хэрэгслийг гардуулан өгч, сургалтын орчин, лабораторийн хэрэглэгдэхүүний хүртээмжийг нэмэгдүүлэх чухал хөрөнгө оруулалт хийгдлээ.



*Физикийн эрчимжүүлсэн сургалтын явцаас*

**Эх сурвалж:** Дорнод аймгийн Боловсролын газар Сургалт арга зүйн хэлтэс, 201 тоот Хэлтсийн дарга Ж.БУМТУЯА Емэйл: [bumtuyaa5fvk@moes.edu.mn](mailto:bumtuyaa5fvk@moes.edu.mn) Утас: 99588832



## ХАМТЫН АЖИЛЛАГАА

Дэлхийн Зөн Олон улсын байгууллагын Дорнод орон нутгийн хөтөлбөрөөс аймгийн сургуулийн өмнөх боловсролын байгууллагад хамрагдаж буй хүүхэд багачуудын эрүүл мэндийг дэмжих, амьсгалын замын халдварт өвчлөлөөс урьдчилан сэргийлэхэд нэн шаардлагатай багаж, төхөөрөмжийн дэмжлэг үзүүлээ.

Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад нийт 16,366,400 төгрөгийн 10 ширхэг хүчилтөрөгчийн коктейлын аппарат, хүчилтөрөгч өтгөрүүлэгчийн хамт Хэрлэн сумын 2,3,5,6,8,11,15,19, Баянтүмэн, Чойбалсан сумдын цэцэрлэгүүдэд гардууллаа.



*Төхөөрөмж нийлүүлэх явцаас*

Тус дэмжлэг нь Дэлхийн Зөн Олон улсын байгууллагын Дорнод орон нутгийн хөтөлбөрөөс он гарсаар боловсролын байгууллагад үзүүлж буй 3 дахь удаагийн дэмжлэг юм.

### **СУРГУУЛЬ, ЦЭЦЭРЛЭГҮҮДЭД 471 САЯ ТӨГРӨГИЙН ҮНЭ БҮХИЙ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙГ ХҮЛЭЭЛГЭН ӨГӨВ.**

Аймгийн орон нутгийн төсөв болон Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр боловсролын байгууллагуудын сургалтын орчин, нөхцөлийг сайжруулах чиглэлээр 471 сая төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмжүүдийг өнөөдөр сургууль, цэцэрлэгүүдэд гардууллаа. Ерөнхий боловсролын сургуулиудад “Цахим анги” тохижуулахад шаардлагатай тоног төхөөрөмжийг Хэрлэн сумын 2 дугаар сургууль, 12 дугаар сургуульд, ерөнхий боловсролын сургуулийн урлаг, гоо зүйн танхимын тоног төхөөрөмжийг Хэрлэн сумын Хан-Уул сургууль болон 1 дүгээр сургуульд, Сургалтын байгууллагын ариун цэврийн өрөөг ялгаатай хэрэгцээт суралцагчдад зориулан тохижуулахад шаардлагатай тоног төхөөрөмжийг Хэрлэн сумын 2, 5, 8, 11, 12 дугаар сургууль, Хан-Уул сургууль, “Шинэ хөгжил” сургуульд, Дотуур байранд шаардлагатай тоног төхөөрөмжийг Халхгол сумын Ялалт багийн сургуульд олгосон байна.



**Эх сурвалж:** Дорнод аймгийн Боловсролын газар Сургалт арга зүйн хэлтэс, 201 тоот Хэлтсийн дарга Ж.БУМТУЯА Емэйл: [bumtuyaa5fvk@moes.edu.mn](mailto:bumtuyaa5fvk@moes.edu.mn) Утас: 99588832

Сургалтын байгууллагын хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг Хэрлэн сумын 5, 8, 12 дугаар сургууль, Хан-Уул сургууль, “Шинэ хөгжил” сургууль, Хөлөнбуйр сумын сургууль, цэцэрлэг, Баянтүмэн сумын сургууль, Сэргэлэн сумын сургууль болон Хэрлэн сумын 2, 5, 12, 15, 16, 19 дүгээр цэцэрлэгүүдэд тус тус гардууллаа.



Тоног төхөөрөмжийг аймгийн Засаг дарга Ш.Ёл боловсролын байгууллагуудын төлөөлөлд хүлээлгэн өгч, хүүхэд, суралцагчдын сурч хөгжих орчин нөхцөлийг сайжруулахад бодит хөрөнгө оруулалтыг цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ гэдгээ илэрхийлэв.

## АНГИ ДЭВШИХ БОЛОН УЛСЫН ШАЛГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛСАН ТУХАЙ

2025-2026 оны хичээлийн жилийн анги дэвших болон улсын шалгалтыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/425 дугаар тушаалаар батлагдсан журам болон Боловсролын үнэлгээний төвийн удирдамжийн дагуу 2026 оны 6 дугаар сарын 3-ны өдрөөс 6 дугаар сарын 12-ны өдрүүдэд нэгдсэн хуваарийн дагуу аймгийн хэмжээнд амжилттай зохион байгуулав.

**Шалгалтын бэлтгэл ажил.** Сургуулиуд шалгалтыг зохион байгуулах бэлтгэл үе шатыг удирдамж, журмын дагуу дараах 5 үндсэн чиглэлээр чанартай хийж гүйцэтгэсэн байна.

### 1. Шалгалтын удирдамж боловсруулж батлуулсан байдал

- **Хэрэгжилт:** Сургууль бүр Боловсролын үнэлгээний төв (БҮТ) болон аймгийн Боловсролын газрын тушаал, зөвлөмжийг үндэслэн өөрийн сургуулийн онцлогт тохирсон "Анги дэвших болон улсын шалгалтыг зохион байгуулах дотоод удирдамж, ажлын төлөвлөгөө"-г боловсруулан сургуулийн захирлаар батлуулан мөрдөж ажилласан.

- **Үр дүн:** Шалгалт эхлэхээс өмнө бэлтгэл ажлыг хангах нарийвчилсан хуваарийг гаргаснаар цаг хугацааны алдагдалгүй, системтэй ажиллах боломж бүрдсэн байна.

### **Шалгалтын материал, даалгаврыг боловсруулж нууцлалыг хангасан байдал**

- **Хэрэгжилт:** Даалгавруудыг Боловсролын газраас ирүүлсэн блюпринтийн дагуу мэргэжлийн багш нар хэлэлцэн, 2-оос 8 хүртэлх хувилбартайгаар боловсруулсан.
- **Нууцлал хангалтын сайн туршлага:** Матад ЕБС, Хан-Уул сургууль, Халхгол Ялалт сургуулиуд шалгалтын материалыг тогтоосон хугацаанаас 1 хоногийн өмнө эсвэл урьд орой нь хэвлэж бэлтгэн, шалгалтын комиссын гишүүдийн хамтарсан хяналт дор тусгай уутанд битүүмжлэн лацадсан. Шалгалтын өглөө уутыг хянагч багш нарын дэргэд

**Эх сурвалж:** Дорнод аймгийн Боловсролын газар Сургалт арга зүйн хэлтэс, 201 тоот Хэлтсийн дарга Ж.БУМТУЯА Емэйл: [bumtuyaa5fvk@moes.edu.mn](mailto:bumtuyaa5fvk@moes.edu.mn) Утас: 99588832



журамд заасан цагт задалж тараасан нь нууцлалыг хамгийн дээд түвшинд хадгалахад чухал үүрэг гүйцэтгэв.

#### **Шалгалтын комисс, хяналтын багийг томилсон байдал**

- **Хэрэгжилт:** Сургуулиудын захирлын тушаалаар (жишээлбэл, Хэрлэн 8-р сургуулийн А/28, Хан-Уул сургуулийн А/21 тоот тушаал) сургалтын менежерүүдээр ахлуулсан 5-12 хүний бүрэлдэхүүнтэй шалгалтын зохион байгуулах комиссыг албан ёсоор томилон ажиллуулсан.
- **Хяналтын механизм:** Хянагч багш нарыг томилохдоо ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлж, өөрийн заадаггүй ангид хяналт тавихаар сэлгэж хуваарилсан (Хөлөнбуйр ЕБС) бөгөөд Халхгол Ялалт сургуулийн адил багш нарын заадаг мэргэжлийг зөрүүлэн хуваарилж, хариуцлагын баталгаанд гарын үүсэг зуруулж баталгаажуулсан байна.

#### **Шалгалтын танхим, техник хэрэгслийн бэлэн байдлыг хангуулсан байдал**

- **Орчин бүрдүүлэлт:** Сурагчдын суудлыг урьдчилан бэлтгэж, нэг ширээнд нэг сурагч суулгахаар зохион байгуулав. Шалгалтын дэг журам сахиулах зорилгоор ухаалаг утас, төхөөрөмж хураах тусгай хайрцаг, савыг анги бүрд бэлтгэсэн.

#### **Суралцагчид болон эцэг эхэд мэдээлэл хүргэсэн байдал**

- **Хэрэгжилт:** Шалгалтын тов, журам, хуваарь болон сонгох шалгалтын чиглэлүүдийг анги удирдсан багш нараар дамжуулан сурагч болон эцэг эхчүүдэд биечлэн болон цахимаар (Viber, Facebook группүүдээр) урьдчилан танилцуулсан.
- **Үр дүн:** Ийнхүү мэдээллийг ил тод, нээлттэй хүргэснээр сурагчид сэтгэл зүйн бэлтгэлтэй шалгалтад ирсэн бөгөөд шалгалтын үед хүндэтгэх шалтгаангүйгээр хоцрох, таслах асуудал үүсээгүй, хамрагдалт 99.52% хүрч өндөр үзүүлэлттэй гарахад нөлөөлсөн.
- **Шалгалтын үр дүнд дүн шинжилгээ хийх.** Шалгалтын үр дүнгийн нарийвчилсан дүн шинжилгээнд үндэслэн сургалтын чанарыг сайжруулах арга хэмжээг төлөвлөх
- **Тэгш оролцоог хангах.** Шалгалтад хамрагдаагүй суралцагчдын нөхөн шалгалтыг хугацаанд нь зохион байгуулах, өвчтэй болон хүндэтгэн үзэх шалтгаантай суралцагчдын мэдээллийг урьдчилан бүрдүүлж, эрсдэлийг бууруулах шаардлагатай байна.

ТАЙЛАН БИЧСЭН: САЗХ-ИЙН ДАРГА

Ж.БУМТУЯА